



ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Баялгийн сангийн төсөв нь нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна.” гэж, Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.58 дахь заалтад “Үндэсний баялгийн сангийн төсөв” гэж Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн дагуу төрөлжсөн сан бүрд төвлөрүүлж, зарцуулах, хуримтлал үүсгэх зорилгоор тухайн жилд Улсын Их Хурлаас баталсан төсвийг” гэж, мөн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1.а дахь заалтад “Ирээдүйн өв сангийн эх үүсвэр нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтворжуулалтын болон Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилаад үлдэх хэсгийн 65 хувь” гэж тус тус заасан нь Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

Олон улсын геополитикийн нөхцөл байдал, худалдаа, эдийн засагт тулгарч буй тодорхойгүй нөхцөл байдлаас шалтгаалж, дэлхийн улс орнуудын эдийн засгийн өсөлт энэ 2025 онд буурах хандлага ажиглагдаж байна. Түүхий эдийн хэрэглээгээр тэргүүлэгч, урд хөрш Бүгд Найрамдах Хятад Ард Улсад үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдлаас үүдэн эдийн засгийн өсөлт, гангийн хэрэглээ буурч байна. Улмаар, манай улсын экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох нүүрсний үнийн бууралт үргэлжилж, төсвийн орлого бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлж байна.

Экспортод гарч буй нүүрсний дундаж үнэ 2025 оны эхний 5 сарын байдлаар тонн тутамд 71.9 ам.долларт хэлбэлзсэн бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 39.0 хувиар буюу 46.6 ам.доллараар буурсан. Нүүрсний үнэ ийнхүү буурснаас шалтгаалж манай улсын экспорт 2025 оны эхний 5 сарын байдлаар 5,424.6 сая

ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 15.0 хувиар буюу 932.9 сая ам.доллараар буураад байна.

Дээр дурдсан нөхцөл байдлын улмаас Үндэсний баялгийн санд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс орох орлогын төсөөллийг гадаад зах зээлийн орчны өөрчлөлттэй уялдуулах шаардлага үүсэж байна.

Түүнчлэн, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтад заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас төрөлжсөн сангийн хөрөнгийн удирдлагын бодлогыг баталж, энэ хүрээнд Ирээдүйн өв сангийн хөрөнгийг гадаад улсын төв банкуудад байршуулан хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж эхлээд байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл 3 зүйлтэй байх бөгөөд доор дурдсан агуулгатай байна. Үүнд:

Нэгдүгээр зүйлд Үндэсний баялгийн санд 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн төвлөрүүлэх орлогын хэмжээ, хуримтлуулах дүнгийн өөрчлөлтийн талаар;

Хоёрдугаар зүйлд Ирээдүйн өв санд 2025 онд орох орлогын өөрчлөлттэй холбоотойгоор Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хууль тогтоомжид оруулах өөрчлөлтийн талаар;

Гуравдугаар зүйлд хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан бүрд 2025 оны төсвийн жилд орлого төвлөрүүлж хуримтлуулж, ингэснээр Үндэсний баялгийн сангаар дамжуулан байгалийн баялгийг хуваарилах Үндсэн хуулийн суурь зарчим хангагдана.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид

бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төсөл байхгүй болно.

---o0o---